

**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015 оны 03 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны хурал 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 10:02 цагт компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын 308 тоот өрөөнд эхлэв. Хуралд хорооны дарга С.Итгэл, гишүүн Т.Доржготов, Б.Сийлэгмаа нар оролцож, хурлыг С.Итгэл даргалав. Хурлын ирц 100 хувь байв.

Хорооны хурлаар Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлаас сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдийн тухай асуудлыг хэлэлцэв.

С.Итгэл: Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлаар сонгогдох Төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүдэд нэр дэвшүүлэх тухай асуудлыг авч хэлэлцэнэ. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч Л.Буянбат, Л.Энхнасан, Ж.Чимэдцэрэн нараас саналаа ирүүлсэн байна. Тухайлбал, Тахько (ХК) компанийн 555,313 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч Л.Буянбат 2015 оны 02 дугаар сарын 26-ны өдөр, 73,675 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч Л.Энхнасан 2015 оны 02 дугаар сарын 25-ны өдөр, мөн компанийн 369,824 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэн 2015 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасны дагуу Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Буянбат, Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир, Б.Батхуяг, Т.Доржготов, Д.Минжмаа, Ж.Чимэдцэрэн, Г.Оюунгэрэл, Г.Ганзул нарын, хараат бус гишүүнээр С.Итгэл, Б.Бямбасүрэн, Б.Сийлэгмаа нарын нэрийг дэвшүүлж байгаа тухай саналаа Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд ирүүлсэн байна. Гишүүдэд нэр дэвшигчдийн талаар асуух асуулт, санал байна уу.

Хорооны гишүүд нэр бүхий хувьцаа эзэмшигчдээс тус хороонд ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай санал, нэр дэвшигчдийн анкетыг уншиж танилцав.

Т.Доржготов: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчид Компанийн засаглалын сургалтад хамрагдаж холбогдох гэрчилгээг авсан уу.

Ш.Мөнх-Очир: Нэр дэвшигчдээс Д.Минжмаа, Г.Ганзул нар шинээр нэр дэвшиж байгаа. Хэрвээ хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдвол компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авах ёстой. Бусад нэр дэвшигчдийн хувьд бүгд компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байгаа.

С.Итгэл: Л.Буянбат, Л.Энхнасан, Ж.Чимэдцэрэн нараас нэр дэвшүүлэх тухай бичгээр ирүүлсэн санал нь Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд мөн хуулийн 66.3, 66.4-д заасан мэдээллийг бүрэн тусгасан учир нэр дэвшигчдийн бүртгэлд бүртгэхэд татгалзах үндэслэлгүй байна. Нийт нэр дэвшигчид нь эзэмшсэн боловсрол, ажилласан хугацаа, туршлага, үүний дотор хараат бус гишүүнд нэр дэвшигчид Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан шалгуурыг хангаж байна гэж үзэж байна.

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5.3 дахь заалтыг үндэслэн нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдох нэрсийн жагсаалтад бүртгэн авч 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх саналыг оруулж байна.



Т.Доржготов: Хувьцаа эзэмшигч болон нэр дэвшүүлэгч нарын бичгээр ирүүлсэн санал нь хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан, мэдээлэл нь бүрэн тусгагдсан тул нэр дэвшигчдийг бүртгэхэд татгалзах зүйлгүй. Нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх саналтай байна.

Б.Сийлэгмаа: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг бүртгэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах саналтай байна.

Хорооны хурлаас ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Л.Буянбат, Л.Энхнасан, Ш.Мөнх-Очир, Б.Батхуяг, Т.Доржготов, Д.Минжмаа, Ж.Чимэдцэрэн, Г.Оюунгэрэл, Г.Ганзул нарыг ердийн гишүүнээр, С.Итгэл, Б.Бямбасүрэн, Б.Сийлэгмаа нарыг хараат бус гишүүнээр сонгогдох нэрсийн жагсаалтад бүртгэж, 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэрийг нь дэвшүүлэхээр шийдвэрлэв.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 10:24 цагт хаав.


ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



(Ш.МӨНХ-ОЧИР)


ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА



(С.ИТГЭЛ)

ГИШҮҮН



(Т.ДОРЖГОТОВ)



(Б.СИЙЛЭГМАА)

